

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот. 2020 он

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР



ФАТФ- Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэгч олон улсын байгууллага



СЗХ- Санхүүгийн зохицуулах хороо



СМА- Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба



ҮМҮЧЭТХЭАЭ- Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч



ЦЕГ- Цагдаагийн ерөнхий газар



ШШГГ- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар



ТЕГ- Татварын ерөнхий газар

Агуулга

1

Хууль эрх зүйн зохицуулалт

2

Тайлагналын тухай

3

МУТС-аас урьдчилан сэргийлэх



I. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллага /ФАТФ/-ын 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтад орсонтой холбогдуулан дээрх чиглэлийн бодлого стратеги, зохицуулалтыг сайжруулах зорилтын хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулж *үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг* тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамааруулан зохицуулах, хяналт тавих үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэхээр хуульчлагдсан.

*Үнэт металл*¹ гэж алт, мөнгө, платина болон түүний бүлэгт багтдаг палладий, иридий, родий, рутений, осмийг хэлнэ.

*Үнэт чулуу*² гэж доржпалам, бадмаараг, маргад эрдэнэ, индранил болон сувдыг хэлнэ.

Тайлбар*

¹ Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалт

² Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь заал

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ БАТАЛСАН ЖУРМУУД

Хуулийн хэрэгжилтийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо дараах журмуудыг баталсан:



150 дугаар
тогтоол

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам

151 дүгээр
тогтоол

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” тогтоолоор зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоосон

179 дүгээр
тогтоол


Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам

182 дугаар
тогтоол


Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам



ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОЛТ, БҮРТГЭЛИЙН ЖУРАМ



Журмын бүтэц



Журмын зорилго:

Арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэхэд тавигдах нөхцөл шаардлагыг тодорхойлох, тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг олгох, олгохоос татгалзах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч




Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч



Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хүрээнд:

1. Үнэт металл, үнэт чулуу худалдах, худалдан авах;
2. Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийг худалдах, худалдан авах үйл ажиллагаа эрхэлнэ.



Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд зөвхөн үнэт металл, үнэт чулууг худалдах, худалдан авах үйл ажиллагаа эрхэлнэ.



Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийг худалдах, худалдан авах үйл ажиллагаа

эрхэлнэ.



АНХААРУУЛГА*

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС ОЛГОСОН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮРЭЭНД ЭРХЭЛНЭ.

ҮМҮЧЭТХЭАЭ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

1	Тусгай зөвшөөрөл хүссэн албан бичиг	Огноо: Дугаар: ...
2	Энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар баталсан маягтын дагуу тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл	Батлагдсан маягтыг гүйцэд бөглөн ирүүлсэн эсэх.
	а) Өргөдөл гаргасан огноо,
	б) Өргөдөл гаргагчийн оноосон нэр,	“...” ХХК
	в) Зөвшөөрлийн төрөл,
3	Тухайн компанийн ТУЗ эсхүл хувьцаа эзэмшигчдийн шийдвэр	Хувьцаа эзэмшигчийн шийдвэр. Хэрэв 2-оос дээш хувьцаа эзэмшигчтэй бол хурлын тэмдэглэлийг ирүүлнэ.
4	Улсын бүртгэлийн албанд бүртгүүлсэн компанийн дүрэм	Дүрэмд Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасныг тусгасан байна.
5	Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийг хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох баримт, гарал үүслийн тодорхойлолт	Цалингийн хуримтлал, хугацаатай хугацаагүй хадгаламжаас үүссэн хуримтлал, компаниас авсан ногдол ашиг, өөрийн өмчлөлийн үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл худалдсан гэх мэт хууль ёсны орлого гэдгийг нотлох баримт бичиг.
6	Хувь нийлүүлсэн хөрөнгөнд ногдох мөнгөн хөрөнгийг өөрийн харилцагч банкны дансанд байршуулсан талаарх банкны тодорхойлолт, хуулга бусад баталгаа	Тусгай зөвшөөрөл хүссэн өдрийн байдлаар.
7	Компанийн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө	
8	Ажлын байрны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түрээсийн гэрээ, техник тоног төхөөрөмжийн талаарх танилцуулга, холбогдох баримт бичиг	Түрээсийн гэрээ эсхүл үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
9	Эрх бүхий албан тушаалтан бүрийн энэхүү журмын 12 дугаар хавсралтаар гаргасан хувьцаа эзэмшигчийн тодорхойлолт	Эрх бүхий албан тушаалтан бүр ТЕГ, ШШГГ, ЦЕГ-ын лавлагаа, тодорхойлолтыг ирүүлэх. /Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1.Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно/
10	Дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажилтны энэ журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт	
11	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1-д заасан дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын хөтөлбөр;	
12	20 сая төгрөг болон түүнээс дээш үнийн дүн бүхий гүйлгээ хийсэн харилцагчийн талаарх мэдээллийг хэрхэн зохицуулах болон хэрхэн хөтлөх талаар зохицуулсан дотоод үйл ажиллагааны журмын төсөл	Жишиг хөтөлбөрийн загварыг www.frc.mn цахим хуудсанд байршуулсан.

ҮМҮЧЭТХЭАЭ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ИРГЭНИЙ БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

д/д	БАРИМТ БИЧГИЙН ТӨРӨЛ	ТАЙЛБАР
1	Гараар бичсэн өргөдөл	Холбоо барих утасны дугаар, гэрийн хаягийг заавал бичсэн байх
2	Энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар баталсан маягтын дагуу үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл	Маягтын өргөдөл гаргасан огноо, тусгай зөвшөөрлийн төрөл болон Хэсэг 3-т заасан мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэх
3	Иргэний үнэмлэх	Нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
4	Энэхүү журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт	Маягтыг үнэн зөв, бүрэн гүйцэд, гаргацтай мэдээлнэ

ТОХИРОМЖТОЙ ЭТГЭЭДИЙГ ТОДОРХОЙЛОХ БАРИМТ БИЧИГ

д/д	БАРИМТ БИЧГИЙН ТӨРӨЛ	ТАЙЛБАР
1	Хорооны 179 дүгээр тогтоолоор баталсан “Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ын 1, 2 дугаар хавсралт дахь асуулгад хариулах	1 дүгээр хавсралт “Эцсийн өмчлөгч буюу хянагчийн асуулга” 2 дугаар хавсралт “Асуулгын хуудас”
2	Дээрх асуулгад үнэн зөв хариулсан талаарх нотлох баримт бичиг	ШШПГ, ЦЕГ-ын лавлагаа, тодорхойлолт https://e-mongolia.mn/home




АНХААРУУЛГА*

ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэж буй **иргэн мөн хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалнуудад** хамааралтай болно.

ЖИЧ: Хуулийн этгээдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн **хэрэгжилт хариуцсан ажилтан** мөн тохиромжтой этгээд байх.

ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС ТӨВЛӨРҮҮЛЭХ


САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 05 сарын 25 өдөр Дугаар 154 Улаанбаатар хот

Тогтоол, журамд нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.5, 6.3.5, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 211 дүгээр тогтоолд дор дурдсан агуулга бүхий долоодугаар хавсралт нэмсүгэй:

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны
 7 дугаар сарын 08-ны 211-р тогтоолын
 долоодугаар хавсралт

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭЛГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН
 АРИЛЖАА ЭРХЛЭГЧЭС ТӨВЛӨРҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН
 ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ

№	Зохицуулалттай үйлчилгээ	Үйлчилгээний хөлс	Хугацаа
НЭГ. Тусгай зөвшөөрөл			
1.1	Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэх этгээд /иргэн/	100,000 төгрөг	Жил бүр
1.2	Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх этгээд /иргэн/	100,000 төгрөг	Жил бүр
1.3	Үнэт металл болон үнэт чулууны арилжаа эрхлэх хуулийн этгээд	300,000 төгрөг	Жил бүр
1.4	Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх хуулийн этгээд	300,000 төгрөг	Жил бүр
ХОЁР. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой бусад үйлчилгээ			
2.1	Улаанбаатар хотод салбар, төлөөлөгчийн газар нээх зөвшөөрөл	100,000 төгрөг	Тухай бүр
2.2	Орон нутагт салбар, төлөөлөгчийн газар нээх зөвшөөрөл	20,000 төгрөг	Тухай бүр
2.3	Онгоосон нэр өөрчлөх зөвшөөрөл	100,000 төгрөг	Тухай бүр

2.4	Тусгай зөвшөөрөл сэргээх	100,000 төгрөг	Тухай бүр
2.5	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралт солих, шинэчлэх, нөхөн олгох	100,000 төгрөг	Тухай бүр

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 211 дүгээр тогтоолын 1 дэх заалтын "... зургаадугаар хавсралтаар" гэсний дараа "Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчээс төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлсийг долоодугаар хавсралтаар" гэж нэмсүгэй.

3. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 211 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан "Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төвлөрүүлэх журам"-ийн 3.3 дахь хэсгийн "...1, 2, 3, 4, 6" гэсний дараа "7" гэж нэмсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдэгдэхийг Ажлын алба /Т.Жамбаажам/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН





ТАЙЛБАР*

ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээд нь зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тухайн оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Хорооны холбогдох дансанд төвлөрүүлнэ. *Жич: Жилд 1 удаа төвлөрүүлнэ.*

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНЫ БОЛОН ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ




Журмын бүтэц



Журмын зорилго:

Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-оос үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч /цаашид “Арилжаа эрхлэгч” гэх/-ийн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд хяналт, шалгалт хийж, холбогдох хууль тогтоомж, журам зааврын хэрэгжилт, учирч болзошгүй эрсдэлийн түвшинг тодорхойлон үнэлгээ, дүгнэлт өгч, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээ авахад оршино.



ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ



Газар дээрх хяналт, шалгалтаар арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, журам зааварт нийцэж байгаа эсэхийг газар дээр нь баримтаар тогтоож, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээг авна.

Газар дээрх хяналт, шалгалтын төлөвлөгөө, газар дээрх хяналт, шалгалтын удирдамж /цаашид “Удирдамж” гэх/-ийг Хорооны дарга батална.



ГАЗАРХ ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ХАМРАХ ХҮРЭЭГЭЭР НЬ



ИЖ БҮРЭН хяналт, шалгалтаар баталсан удирдамжийн хүрээнд холбогдох баримт бичигт тулгуурлан арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг бүхэлд нь хамруулж, үнэлэлт, дүгнэлт өгнө.

ХЭСЭГЧИЛСЭН хяналт, шалгалтаар харилцагчдаас болон холбогдох бусад байгууллагаас ирсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, эсхүл Хорооноос шалгах шаардлагатай гэж үзсэн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шалгаж үнэлэлт, дүгнэлт өгнө.

Удирдамж

Удирдамжид шалгалтын зорилго, үндэслэл, шалгалтын төрөл, хүрээ, шалгалтад хамрагдах байгууллагын нэр, шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүн, шалгалт эхлэх болон дуусах хугацааг тусгана

Газар дээрх хяналт, шалгалтын ангилал

Иж бүрэн, хэсэгчилсэн

Шалгалт эхлэх

Удирдамжийг шалгалтад хамрагдах байгууллагад танилцуулснаар шалгалтыг эхлүүлнэ

Иж бүрэн хяналт, шалгалт

Шалгалтад хамрагдаж буй байгууллагаас журмын 3.6.1-3.6.10-г заасан баримт бичгийг шаардана.

Хэсэгчилсэн хяналт, шалгалт

Хэсэгчилсэн хяналт, шалгалтад хамрагдах байгууллагаас удирдамжид заасан баримт бичгийг шаардана.

Шалгалтын тайлан

Журмын 3.8-3.10 дахь заалтуудад шалгалтын тайлан, үүрэг даалгаврын биелэлтийн талаар тусгасан.

ЗАЙНЫ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

Зайны хяналт, шалгалтаар салбарын болон арилжаа эрхлэгчийн болзошгүй эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.



1

Тайлан, мэдээг хянаж, үндсэн үйл ажиллагааны болон цаашид үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлж үнэлэлт, дүгнэлт өгөх;

2

Тайлан, мэдээг ирүүлээгүй, ирүүлсэн тайлан, мэдээ нь шаардлага хангаагүй бол тухайн арилжаа эрхлэгчээс шаардлага хангасан тайлан мэдээг нэн даруй ирүүлэхийг шаардах;

3


Үндсэн үйл ажиллагаа, санхүү төлбөрийн чадварыг нь сайжруулах чиглэлээр хугацаатай үүрэг даалгавар өгөх;

4

Шаардлагатай гэж үзвэл арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалт хийх саналыг Хорооны холбогдох удирдлагад танилцуулна.

5

Шаардлагатай тохиолдолд нэмэлт тайлбар, мэдээлэл, холбогдох баримт бичгийг шаардах



Арилжаа эрхлэгчээс ирүүлсэн тайлан мэдээг хянаж, эрсдэлтэй гэж дүгнэсэн тохиолдолд тайлангийн хариуг цахимаар болон албан бичгээр хүргүүлнэ.



II. ТАЙЛАГНАЛ

ИРҮҮЛБЭЛ ЗОХИХ ТАЙЛАН МЭДЭЭ



Санхүүгийн тайлан болон комплаенсын эрсдэлийн үнэлгээний тайланг **хагас, бүтэн жилээр** гаргаж Хороонд ирүүлнэ



Бизнесийн болон бүтцийн эрсдэлийн үнэлгээний тайланг **улирал бүрийн** дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.




Журмын 4.3.1-4.3.5-д заасан үндсэн үйл ажиллагааны мэдээг **сар бүр** гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд цахимаар ирүүлнэ



Журмын 4.3.6-д заасан мэдээлбэл зохих гүйлгээ, харилцагчийн бүртгэлийн мэдээг **сар бүр** гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд цахимаар ирүүлнэ

ТАЙЛАН МЭДЭЭГ ТАТАХ



Цахим Тайлан

2015 оны 1-р улирлаас эхлэн БССБ, ХХМ-ны Зохицтой хэрэгсэлийн тайланг цахимаар авчлаас гадна онлайнаар хүлээж авах боломж тухай тайланг шалгахад шалтгаан нэвчлэл үзэх боломж болон БССБ-д мэдээллийг 70117098 дугаарын утсаар лавлана уу. Цахимаар илгээхийн тулд дээрхи Мастер-файлыг татаж авах шаардлагатай. Мөн хэлбэрд оруулсан заавал бичлэг ширээнд илгээх аргаарна уу.

БССБ цахимаар илгээх мастер-файлыг энд дэж татаж авна уу.
Монгол банкны 2015 оны 09 дугаар сарын 21 өдрийн зарлисан хэргийг энд дэж авна уу.
Цахим тайланг шалгах аргаар авчирч энд дэж авна уу.

Цахим тайланг шалгах байдлыг үнэлэх түүхэнхэл тулгардаг асуудлууд



Вэбээр илгээх

Тайлбар: цахим болгож буй интернэт хэлтэс: Google Chrome татах



Мастер-файлыг илгээх

Одоогоор ашиглагдаж буй стандарт: MS Excel 2003

WWW.FRC.MN



WWW.FRC.MN


ЦАХИМ
ТАЙЛАН

МАСТЕР
ФАЙЛААР
ИЛГЭЭХ

Тайлбар*

Мастер илгээх тухайн мастер татна. файлаар цэснээс тайлангийн файлыг

ТАЙЛАН МЭДЭЭГ ИЛГЭЭХ ЗААВАР



WWW.FRC.MN


WWW.FRC.MN

ЦАХИМ
ТАЙЛАН

МАСТЕР
ФАЙЛААР
ИЛГЭЭХ

Тайлбар*

Вэбээр илгээх
цэсийг сонгон
Хорооноос олгосон
нэр, нууц үгээр
нэвтрэнэ.



Тайлбар*

Вэбээр илгээх
цэсээр нэвтрэн
НУУЦ ҮГИЙГ
заавал солино уу.

ТАЙЛАН МЭДЭЭГ ИЛГЭЭХЭД ГАРАХ АЛДААНЫ ТАЙЛБАР

ИЛГЭЭГДСЭН

ХӨРВӨСӨН

**ФАЙЛЫН НЭР
БУРУУ**

ТАТГАЛЗСАН

**ГАРЫН ҮСЭГ
БУРУУ**

СБ БУРУУ

**МАТРИЦЫН
АЛДАА**

Илгээгдсэн- Тайланг хүлээн авсан.

Хөрвөсөн- Мастер файлын алдааг шалгаж байна. Шүүлтүүр хийх;

Файлын нэр буруу- Мастер файлын нэршлийг буруу өгсөн, эсхүл MS EXCEL 97-2003 өргөтгөлтэй хадгалаагүй;

Татгалзсан- Мастер файлын нэрийг өгөхдөө хугацааг ирээдүй цагаар өгсөн, эсхүл хянан шалгагч ирүүлсэн тайланг зөвшөөрсөн байхад тайлан, мэдээг дахин илгээхэд тус алдаа илэрнэ.

Жишээ нь: 2018 оны 3 дугаар сард арилжаалсан үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн мэдээг илгээхдээ файлын нэрийг DPMSM1234567m042020

Гарын үсэг буруу гэсэн алдаанд дараах алдаануудыг тодорхойлно. Үүнд:

1. Мастер файлыг эксел програм дээр нээгээгүй Open office, libre office зэрэг програмуудаар нээхэд хамгаалалтгүй болдог тул тус алдааг заана.
2. Хуудасны хамгаалалтын алдаатай гэж заавал дараах дугаарт хандана уу. **Утас: (51) 263425, (51) 262607, (51) 262604**
3. Шифр буруу байвал мастер файлыг дахин өөр талбарт хадгалан дахин илгээнэ. /Мастер файлыг олон татсан/
4. Санхүүгийн программаас татсан мастер файл бус Хорооны цахим хуудаснаас татаж шивэх.

Санхүүгийн байгууллага буруу гэсэн алдаанд дараах алдаанууд хамрагдана. Үүнд:

1. Регистрийн дугаар буруу
2. Өөр иргэн, хуулийн этгээдийн нэрээр нэвтэрсэн.

Матрицын алдаа:

1. Сарын мэдээг улирлын тайлангийн нэршлээр нэрлэх.
2. Буруу мастер файлаар илгээхэд.

Импорт төлөвийн мэдээлэл: TPD6044891m012018.xls :: 2018-01-01 - 2018-01-31

Код	Төрөл	Хувилбар	Импорт эхлэл	Импорт төгсгөл	Төлөв
TPD	ИМЭЙЛ_PC ORIG		2018-05-22 17:05:06	2018-05-22 17:05:07	Бүтэцэн
TPD	ИМЭЙЛ_PC ORIG		2018-05-22 17:05:06	2018-05-22 17:05:07	Бүтэцэн

Мэдээлэл: Warn: Unable to import accepted return

Download import log | Тогтмол дахин сэргээх | Сэргээх

ТАЙЛБАР*

Таны илгээсэн тайлан зөвхөн илгээгдсэн төлөвтэй байвал Фина систем хүлээн авсан болно.

Тайлангийн алдаа харах тайлбарыг зурагт харуулав.

III. МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

МӨНГӨ УГААХ гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг хэлнэ.

Гэмт хэрэгтнүүд их хэмжээний бэлэн мөнгийг дараах хууль бус үйл ажиллагаанаас олдог бөгөөд мөнгө угаах гэмт хэргийн үндэс болдог. Үүнд:

- Хууль бус галт зэвсгийн наймаа;
- Хүний, эд эрхтний наймаа;
- Хар тамхины худалдаа;
- Бусдын биеийг үнэлүүлэх;
- Мөнгөн тэмдэгт хуурамчаар боловсруулах;
- Авлига, хээл хахууль;
- Татвараас зайлсхийх;
- Байгаль орчны эсрэг, гэмт хэрэг;
- Хулгай, дээрэм;
- Цахим гэмт хэргийн хохирогчоос шаардаж авсан барьцаа төлбөр, далд веб дэх хууль бус үйл ажиллагааны төлбөр болгож биткойн, этериум зэрэг криптовалютаар олсон орлого гэх мэт



МУТС ГЭМТ ХЭРЭГТ ӨРТӨХ ЭРСДЭЛ:

- Тансаг эдлэл, үл хөдлөх хөрөнгө худалдан авах, авсан эд зүйлээ хууль бусаар хилээр гарган, олсон хууль бус орлогоо буцаан оруулж, эргэлтэнд оруулах
- Төрийн зарим албан хаагчид албан тушаалын байдлаа урвуулан ашиглан, хээл хахуулийн журмаар олсон хууль бус орлогоо гадаад, дотоодын банкны тогтолцоогоор дамжуулан хууль ёсны мэт болгохыг оролдох
- Төрийн өмчит компанийн удирдлагад ажиллаж байсан зарим хүмүүс албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хуурамч гэрээ байгуулан, хөрөнгө мөнгийг гадаадын хэд хэдэн улс руу гарган, буцаан оруулж ирэх гэх мэт эрсдэлд өртөх боломжтой.
- Дээрх түгээмэл тохиолдлуудад гэмт хэрэгтэн нь гуравдагч этгээд, энгийн **ИРГЭНИЙ** баримт бичиг мэдээллийг ашиглан хууль бус үйлдэл гүйцэтгэх боломжтой юм.

МЭДЭЭЛЭХ ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭХ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “дараах этгээд энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан гүйлгээний талаар энэ хуулийн 16.1-д заасан Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй” гэж заасны дагуу үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч нь 7 дугаар зүйлд заасан гүйлгээг мэдээлнэ. Үүнд:

7.1. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.

7.2. Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.

7.3. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд болон Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлд заасан этгээд мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэл ирүүлэх журам, маягтын дагуу цахим хэлбэрээр ирүүлнэ.
/Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А26 тушаал, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А-326 дугаар тушаал /

7.4. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд Монголбанкны Ерөнхийлөгч, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан мэдээлэл өгөх журмын дагуу тодорхой гүйлгээ, түүнд оролцогч талуудын тухай мэдээллийг эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад гаргаж өгнө.

7.5. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд шаардлагатай тохиолдолд Санхүүгийн мэдээллийн албаны даргын зөвшөөрснөөр цаасан хэлбэрээр ирүүлж болно.

НҮБ-ЫН АЮУЛГҮЙН ЗӨВЛӨЛИЙН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТТАЙ ХАРИЛЦАГЧДЫН НЭРСИЙГ ТУЛГАХ ЦАХИМ ХУУДАС

The screenshot displays the homepage of the Mongolian Anti-Money Laundering and Counter-Terrorism Financing Center (AMLCFT). At the top right, there is a language selection button labeled "ENG". The main header features the title "МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ". Below this is a dark navigation bar with menu items: "НҮҮР", "ТОГТОЛЦОО", "МЭДЭЭ", "ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ", "ҮНДЭСНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ", "СҮРГАЛТ", "ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ", and "НЭВТРЭХ". The main content area is divided into two columns. The left column features a large image of a building with the sign "АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР" and a headline "АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛД ХАМААРАХ 48 ГОМДЛЫГ ХЯНАН ШАЛГАВ" dated "2020 оны 11 сарын 10". The right column, titled "ОНЦЛОХ МЭДЭЭ", contains three news snippets: 1) "ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2021 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙГ УИХ..." dated "2020 оны 11 сарын 10"; 2) "МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГТ ТООЦОГДДОГ ТҮГЭЭМЭЛ 30 ХЭЛБЭР" dated "2020 оны 11 сарын 03"; 3) "Монгол Улсыг 'Саарал жагсаалт'-аас шийдвэр ФАТФ-ын нэгдсэн хуралдаанаар ө..." with a logo for "САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО". At the bottom of the page, a dark blue banner reads "НҮБ-ЫН АЮУЛГҮЙН ЗӨВЛӨЛӨӨС ГАРГАСАН ХОРИГ ЖАГСААЛТ".

Тайлбар*

НҮБ-ийн Аюулгүй зөвлөлийн хориг арга хэмжээний жагсаалттай харилцагчийг заавал тулгаж шалган, бүртгэлийг дотооддоо хөтөлнө.

WWW.AMLCFT.MN





www.frc.mn



51-264444



webmaster@frc.mn



www.facebook.com/FRC.of.Mongolia



Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160